



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Ш.Энхтүвшинг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоол, Монгол Улсын "Төрийн албаны тухай хуулийн 23.3.2, 30- дугаар зүйлийн 30.4.3, Албаны дотоод журмын 7.4/г/ тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Мэргэжилтэн Шаравдорж овогтой Энхтүвшин нь эрүүл мэндийн байдлын улмаас төрийн албанаас түр чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул 2012 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Ш.Энхтүвшин нь нэг жил өвчтэй байсан ба хүнд өвчний учир төрийн албанаас чөлөөлөгдөж байгаа байдлыг харгалзан үзэж 150.000 /нэг зуун тавин мянган /-төгрөгийн буцалтгүй тусламжийг нэг удаагийн буцалтгүй тусламжаас олгохыг нягтлан бодогч / П. Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

3. Ш.Энхтүвшингийн ажлыг төрийн албаны сул орон тоог нөхөх журмын дагуу сонгон шалгаруулалтаар хүн сонгох авах хүртэлх түр хугацаагаар мэргэжилтэн Х.Галымбект хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

4. Ш.Энхтүвшинтэй эд хогшил, холбогдох бусад тооцоо хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн Б.Сүхбаатар, нягтлан бодогч П.Ариунаа нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН